

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.060.10

Байгаль орчны хамгаалал, усан мандал Газрын доорх усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлага Охрани природы. Гидросфера. Охрана подземных вод от загрязнения. Общие требования.	MNS 3342:1982 СТ СЭВ 3079-81
--	---

Үнэ, стандартын улсын хорооны 1982 оны 111 дүгээр тогтоолын дагуу 1983 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн дагаж мөрдөнө.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө

Энэ стандарт нь газрын доорхи усыг бохирдохоос хамгаалах ерөнхий шаардлагыг тогтооно.

Стандарт нь СТ СЭВ 3079-81 -д бүрэн тохирно.

1. Аливаа аж, ахуй, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд газрын доорхи усыг бохирдлоос хамгаалах зорилгоор дараах үйлдлэлийг хориглоно.

1.1 Бүх төрлийн бохир усаар газрын доорхи усыг бохирдуулах;

1.2 Үйлдвэрийн түүхий эд, бүтээгдэхүүний болон үйлдвэрийн хаягдал ба нийтийн ахуйн гаралтай хуурай хог хаягдал, хадгалах, тээвэрлэх үед газрын доорхи усны нөөцийг бохирдуулах.

1.3 Газар тариаланд үр, бордоо болон хортон устгалын бодис хэрэглэх механикжсан ферм, тасаг зэрэг мал аж ахуйн төвүүдэд малыг бордох тэжээх ба саах ажиллагаандаа ус бохирдуулах элдэв зүйлийг газрын доорхи усанд оруулах;

1.4 Газрын доорхи усны нөөцтэй гидравлик холбоотой булаг, горхи, гол мөрөн болон бусад гадаргуугийн усыг бохирдуулах.

2. Түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрийн ба нийтийн аж ахуйн хаягдлыг хадгалах зориулалттай нөөцлөх савыг газрын доорхи усны нөөцийг бохирдуулж болзошгүй талбайд барьж байгуулж ашиглахдаа дараах зүйлийг хатуу мөрдлөг болгоно. Үүнд:

2.1 Нөөцлөх сав байгуулах газрын геологи – гидрогеологийн хайгуулын материал хөрсний шүүрэлтийн тооцоо өөрчлөлтийн төлөв болон уг саванд хадгалах зүйлээс усыг бохирдуулж болзошгүй бодисын хэмжээ, онцлогийг үндэслэн газрын доорхи усыг хамгаалах арга хэмжээг боловсруулна.

2.2 Нөөцлөх савыг ашиглалтад орохоос өмнө нь туршиж ус нэвчихгүй байх нөхцөлөөр хангана.

2.3 Уулын бээлий, хормойн хошуу туудас, шлейфийн эх, голын доод зэрэг ба ихээхэн ан цавтай хэсэг зэрэг геологийн хурдсууд дахь газрын доорхи ус нь ундны ус хангамжинд ашиглагдаж байвал энэ усны тэжээл авах бүсэд нөөцлөх сав байгуулж болохгүй.

MNS 3342:1982

3.1 Усалгааны горим нь хөдөө аж ахуйн таримлын тариалалтын шаардлагын дагуу хамгийн бага шүүгдэх нөхцөлийг хангана.

3.2 Усалгаатай талбайн идэвхт үеийн / зоны аэрацийн / зузааныг нэмэгдүүлэхээр байвал тусгай тооцсон хэмжээнд хүртэл хөрсний усны түвшинг бууруулах нөхцөлийг хангана.

4. Газар тариаланд эрдэс бордоо, хогийн ургамал , хортонтой тэмцэх ба бусад химийн бодисуудыг хэрэглэхдээ манай улсад мөрдөгдөж байгаа холбогдох норм стандарт, бусад дүрэм журмыг удирдлага болгоно.

5. Нефть, нефтийн бүтээгдэхүүнийг олзворлох, хадгалах ба тээвэрлэхдээ энэ талаар тус оронд мөрдөгдөж байгаа холбогдох дүрэм журмыг удирдлага болгоно.

6. Радио идэвхит бодисыг гагцхүү газрын доорхи усыг бохирдуулахгүй байх нөхцөлд хэрэглэнэ.

7. Геологи хайгуулын ажил явуулах, ил уурхайн аргаар ашигт малтмалын орд газрыг ашиглах үед болон бусад ажлын үед уст үеийг илрүүлэхэд газрын доорхи усны нөөцийг бохирдох , хорогдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг урьдчилан авч хэрэгжүүлнэ.

8. Цооног өрөмдөхдөө уст үеүдийг хаах, тэрчлэн гадаргуугийн усны уг цооногт оруулахгүй байх нөхцлийг бүрэн хангах ёстой.

9. Цооногийг угаах, туршилтын шахалт ба дүүргэх үйл ажиллагааг газрын доорхи усыг бохирдуулахгүй цэвэр усаар гүйцэтгэнэ.

10. Ямар нэгэн аваар, гэмтлийн улмаас газрын доорхи усыг их бага хэмжээгээр бохирдуулсан үед тэр газарт хил хязгаар тогтоож хамгаалах, хальж урссан ба асгарсан бодисыг цааш нь тараахгүйгээр , цуглуулах , энэ бүсээс ундаа, ахуйн зориулалттай ус авахыг зогсоох болон гэмтэлд орсон ул мөрийг арилгах арга хэмжээг цаг алдахгүй шуурхай зохион байгуулна.

11. Газрын доорх ус бохирдож байгаа буюу бохирдолт аюултай болох үед газрын доорхи усны чанар, горимд хийх ажиглалтын хэмжээ хяналтын аргыг түүний зориулалт, ашиглалтын төрөл болон бохирдсоноос учирч болох үр дагавраас хааруулан тодорхойлно.

12. Усны чанарт нөлөөлөх ямар нэгэн бохирдуулагч зүйл агуулсан шингэнийг газрын хөрсөөр дамжуулж зайлуулахдаа хөрсний усны түвшин доор бөгөөд гадаргуугаар урсаж тархан газрын доорхи усанд нөлөөлөхөөргүйгээр аажмаар шүүрч байх нөхцөлийг хангасан байна.

13. Голын жигд тархсан тунамал хурдас дээр байршиж байгаа төв суурин газруудад өнгөн хөрсний усыг бохирдуулахгүйн тулд ахуйн бохир, хаягдлыг тусгай доторлогоотой нүхэнд хадгалж зайлуулна.

ТӨГСӨВ